



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/908

Чингис хот


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "а", Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5, 2.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол - Оросын найрамдлын өдрүүдийн хүрээнд Дорноговь аймагт зохион байгуулагдах орос хэл, соёлын бүсийн цогц арга хэмжээнд оролцох багш, сурагчдын замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 122400 /нэг зуун хорин хоёр мянга дөрвөн зуу/ төгрөгийн хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010875